107

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.09.04 № хэг/1620

танай _____-ны №_____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХТУЯА ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын салбарын багш, ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааны асуудал хэрхэн туссан талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Таны асуулттай танилцлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.4-т "Энэ хуулийн 46.3-т заасны дагуу ёсчилсон хуулийг Тамгын газар ажлын 2 өдрийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт илгээнэ.", 46.5-д "Энэ хуулийн 46.4-т заасны дагуу илгээсэн хуулийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн хууль, тогтоолыг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ.", 46.9-д "Хууль, тогтоолыг "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд цаасан болон цахим хэлбэрээр албан ёсоор нийтэлнэ." гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийнээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоол "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд албан ёсоор нийтлэгдээгүй байх тул Таны асуултын хариуг хуульд заасан хугацаанд хүргүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсээд байна.

Иймд "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоол "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд албан ёсоор нийтлэгдсэний дараа Таны асуултын хариуг яаралтай хүргүүлэхийг үүгээр уламжилж байна.

Хувийг: Боловсролын сайд П.Наранбаярт.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ

000245017057

108

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон Ажилчин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 04 17, Факс: (976-51) 26 24 04,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.09.24 № ХЭГ/1794

танай ____-ны №____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХТУЯА ТАНАА

Асуултын хариу хүргүүлэх тухай

Боловсролын салбарын багш, ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааны талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуултын хариуг Боловсролын сайдаас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцахыг хүсье.

Хавсралт А4. хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА —Н.УЧРАЛ

00024501710

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙД

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Багa тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, И-мэйл: letter@moe.gov.mn
Вэб сайт: moe.gov.mn

2024.09.23 № 1/1139

танай_____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Асуултын хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас боловсрролын салбарын багш, ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааны асуудалтай холбогдуулж Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандсан асуулттай танилцлаа.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-г баталж, эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдсэн тул гишүүний асуулттай холбоотой тайлбар, мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудастай.

П.НАРАНБАЯР

14246 0588

Хавсралт

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас
Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд тавьсан асуултын хариу

1. 2023 оны 9 дүгээр сараас боловсролын салбарын багш, ажилтнуудыг төлөөлж Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбооны зүгээс үндсэн цалинг 1000 доллартой тэнцэхүйц хэмжээнд хүргэх талаар Засгийн газар, Боловсролын яаманд удаа дараа шаардлага хүргүүлж ирсэн. 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд өрсөлдөж, өнөөдрийн хамтарсан Засгийн газрыг бүрдүүлж байгаа Монгол Ардын Нам, Ардчилсан Нам, ХҮН намуудын мөрийн хөтөлбөрт ч багш, ажилтны үндсэн цалин улсын дундаж цалингаас үлэмж доогуур байгаагаас шалтгаалан олон мянган багш, ажилтан боловсролын салбараас дүрвэж, цалин хөлс өндөр өөр ажилд шилжиж, гадаад улс орон руу ажиллах хүчин болж явж эхэлснээр боловсон хүчний хомсдолд ороод байгаа нь нууц биш юм. Хамтарсан Засгийн газрын зүгээс 2024-2028 онд багш, ажилтны үндсэн цалинг (цалингийн доод хэмжээ) хэдэн хувиар нэмэгдүүлж, хэдэн төгрөгт хүргэх зорилт дэвшүүлсэн талаар

Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" батлагдсан. Хөтөлбөрт цалин хөлстэй холбогдох асуудлаар "2.1.2.2.Хөдөлмөрийн зах зээлд эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангасан цалин хөлсний тогтолцоог бий болгоно", "2.1.2.7.Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлнэ" гэж туссан бол боловсролын салбарын тухайд "2.2.3.3. Багшийн хөдөлмөрийн бүтээмжийг бодитоор үнэлж, багш, ажилчдын цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг төсөв, мөнгөний бодлоготой уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлж, улсын дундаж хэмжээнд хүргэж, нийгмийн баталгааг хангана" гэж туссан.

Засгийн газрын тухай хуульд зааснаар ажилтны цалин, амьдралын өртгийн талаарх асуудал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудалд хамаарах тул багш, ажилтны үндсэн цалинг (цалингийн доод хэмжээ) нэмэгдүүлэх асуудлыг Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгах юм. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас тодруулах нь зүйтэй.

Үндэсний статистикийн хорооноос 2024 оны 09 дүгээр сарын 16-нд гаргасан мэдээлэлд дурдсанаар 2024 оны 2 дугаар улирлын байдлаар аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын голч цалин 2027.0 мянган төгрөг, улсын хэмжээнд нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 2024 оны 1 дүгээр улиралд 2,283.7 мянга, 2024 оны 2 дугаар улиралд 2,464.9 мянган төгрөг байна. Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн мэдээлэлд үндэслэн сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын багш, арга зүйчийн дундаж цалин 2,698.4 мянга, ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, сургалтын менежер, захирлын дундаж цалин 2,435.5 мянган төгрөг байна.

2. Боловсролын салбарын багш, ажилтнуудаас авсан судалгаанаас үзэхэд 80 гаруй хувь нь хүний амьдралын анхдагч хэрэгцээ болсон орон сууцны нөхцөл нь хүнд байдалтай байгаа нь харагддаг. Үүний үндсэн шалтгаан нь нөгөө цалин хөлс үнэлэмж доогуур, ипотекийн зээлийн шаардлага нөхцөлийг хангаж чадахгүй байгаатай холбоотой. Олон мянган багш, ажилтнууд орон сууцны нөхцөлөө л сайжруулах гэж өөр ажил руу шилжих, гадаадад гарч байна. Иймд хамтарсан Засгийн газрын зүгээс боловсролын салбарын багш, ажилтнуудыг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцтай болгох түсгай хөтөлбөр гарган хэрэгжүүлэх шаардлагатай байгаа тул 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө хэдэн багш, ажилтныг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцтай болгох зорилт дэвшүүлэх тухай

Боловсрол, шинжлэх ухааны яам /хуучнаар/-аас 2023 онд сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагын нийт 41254 багш, ажилтнаас авсан судалгааны дүнгээс харахад судалгаанд хамрагдсан багш нарын 4.6-9.05 хувь, удирдах ажилтны 4.57 хувь, ажилтны 3.74 хувь нь банкны нөхцөлөөр орон сууцны зээлтэй байна.

Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т багш, ажилтныг орон сууцаар хангах асуудлаар "2.1.1.1. Нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулж, иргэн бүрд хуримтлалын сан бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар ашиглах, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах боломжийг бүрдүүлнэ.", "1.4.1.2.Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан болон аймаг, сум, Улаанбаатар хотын алслагдсан дүүрэгт анх удаа орон сууц худалдан авах иргэдэд арилжааны банкнаас олгох ипотекийн зээлийг 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ", "1.4.1.5.Бүсийн хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгааг хангах төсөл, арга хэмжээ, түрээсийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ", "4.2.3.9. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтлан орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлнэ. Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч байгаа иргэд хөдөлмөр эрхлэх, жижиг, дунд, бичил бизнесийн салбарт ажиллах, орлого олох, баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ" гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн "Боловсролын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 326 дугаар тогтоолын 3-т багшийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах боломжийг судлан, төсөл, арга хэмжээний саналаа 2024 оноос үе шаттай хэрэгжүүлэхээр тооцож танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасан. Багшийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах асуудлыг дээрх 2 яамдтай хамтран судалж ажиллахад татгалзах зүйлгүй болно.

3.2019 онд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор хуралдсан Монголын багш нарын 7 дугаар их хурал, 2024 онд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн ивээл дор хуралдсан Монголын багш нарын 8 дугаар их хурал, Боловсролын ерөнхий хуулийг шинэчлэн батлагдахад салбарын багш, ажилтнуудаас тэтгэвэрт гарах насыг өөрөө хүсвэл эмэгтэй 50, эрэгтэй 55 нас болгох асуудал байсан. Хамтарсан Засгийн газар энэ асуудлыг хэрхэн

шийдвэрлэх вэ?

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2024 оны 04 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Монголын багш нарын VIII их хурлаас "Багш нарын VIII их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Тогтоол гарсан. Тус тогтоолын 3.11-т "Боловсролын сургалтын байгууллагын багшийн тэтгэврийн насыг өөрөө хүсвэл эмэгтэй багшид 50, эрэгтэй багшид 55 болгох чиглэлээр холбогдох яамтай хамтран санал боловсруулж, зөвшилцөх, их хуралд өргөн барих" гэж заасан.

2022-2024 онд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Ажил мэргэжлийн стандарт хүний хөгжлийн хүрээлэн болон салбарын үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн багш, сургалтын менежер, захирал, цэцэрлэгийн багш, багшийн туслах, арга зүйч, эрхлэгчийн гүйцэтгэж буй ажил үүргийн үнэлгээ, судалгаа хийсэн. Судалгаагаар бага ангийн багш сургалтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулах, суралцагчийн дэвтэр засах ажлыг байнга хийдэг маш чухал, хүнд ажил гэж нэрлэсэн бол багшид ачаалал үүсгэж байгаа үндсэн хүчин зүйл нь нэг багшид ногдох хүүхдийн тоо их байгаа байдал гэж үзсэн байна.

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны багшийн ажлын чиг үүрэгт 2022-2023 онд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Ажил мэргэжлийн стандарт хүний хөгжлийн хүрээлэн болон салбарын үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран хийсэн шинжилгээгээр "багшийн хөдөлмөрийн нөхцөл "хэвийн" гэж тогтоогдсон тул тухайн албан тушаалд ажиллаж байгаа иргэний өндөр насны тэтгэвэр тогтоох насанд өөрчлөлт оруулах үндэслэл одоогоор байхгүй гэж үзсэн. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Боловсролын ерөнхий хууль батлагдсан бөгөөд хуулийн төсөл хэлэлцэх явцад бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа багшийн өндөр насны тэтгэвэрт гарах настай холбогдох харилцааг боловсролын салбарын хууль тогтоомжоор зохицуулах боломжгүй болохыг УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанаас ажлын хэсэгт чиглэл өгсөн. Тэтгэвэр тогтоох насыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ар зохицуулна.

4. Засгийн газар холбогдох яамдын зүгээс боловсролын салбарын багш, ажилтнуудын ажлын байран дахь хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуй, аюулгүй байдлын эрсдэл, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг шинжлэх ухааны үндэслэлтэй бүрдүүлэх чиглэлээр ямар ямар арга хэмжээ авч байгаа талаарх мэдээллийг тус тус ирүүлнэ үү.

Боловсролын салбарын чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр 2022 оноос сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүнд эрүүл мэндийн үйлчилгээний зардал багтах болсон. Ингэхдээ цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, коллеж, их, дээд сургуулийн багш нарын эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлж, эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, цаашид урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний төрлийг тогтоох зорилгоор "Багшийн эрүүл мэндийн тандалт"

асуумж-судалгаа /www.esis.edu.mn/-ны үр дүнд үндэслэсэн. Асуумж-судалгаагаар багш нарын дунд бөөр, шээсний замын эмгэг /23.7%/, зүрх судасны эмгэг /21.4%/, хоол боловсруулах тогтолцооны эмгэг /17.1%/, харшлын эмгэг /14.8%/, дуу авианы өвчлөл /14.9%/ зэрэг эмгэгүүд зонхилж байсан болно.

Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 28-ны 53 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан нэг суралцагчид ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүнд эрүүл мэндийн үйлчилгээний зардал сургуулийн өмнөх боловсролд байршлаас хамаарч 2.213-0.263 хувь, ерөнхий боловсролд 0.22-0.271 хувь эзэлж байна.

Эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамрагдаж буй багш, ажилтан нь хамар залгиурын арчдас, нян тээгч илрүүлэх, цагаан хорхой буюу шимэгч хорхойн өндөг илрүүлэх шинжилгээ, сүрьеэгийн үзлэг, рентген зураг харалтын шинжилгээ, арьсны халдварт өвчний үзлэг, бамбайн даавар (TSH буюу ТТГ) илрүүлэх шинжилгээ (2 жил тутамд), хеликобактери илрүүлэх шинжилгээ, дууны хөвчийн дурангийн оношилгоо (40 дээш насанд 3 жил тутамд), цагаан хорхой буюу шимэгч хорхой илрүүлэх шинжилгээ зэргийг харьяа аймаг, сум, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн яамнаас зохих зөвшөөрөлтэй эмнэлэг, лабораторид хийлгэж байна.

2023 оноос Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийг түшиглэн Багшийн эрүүл мэндийг дэмжих төв үйл ажиллагаа явуулж байна. Багш нар өрхийн болон аймаг дүүргийн эрүүл мэндийн төвийн үзлэгийн мөрөөр гуравдугаар шатлалын эмнэлэгт хандах шаардлага үүсвэл сургууль, цэцэрлэгийнхээ эмчээр дамжуулан Багшийн эрүүл мэндийг дэмжих төвд хандах үйлчилгээ авч, шаардлагатай тохиолдолд гуравдугаар шатлалын бусад эрүүл мэндийн байгууллагад мөн холбон зуучилдаг болно. Багшийн эрүүл мэндийг дэмжих төвд эрүүл мэндийг дэмжих төвийн үйлчилгээ авахаар нийт 625 хүсэлт ирснээс нийслэлээс 321, орон нутгаас 304 хүсэлт ирсэн ба дийлэнх нь буюу 394 /63%/ нь багш нараас ирүүлсэн байна. Нийт ирсэн хүсэлтээс сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагаас 201 /32.2%/, ерөнхий боловсролын сургуулиас 401 /64.2%/, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас 23 /3.7%/ хүсэлт ирсэн байна. Мөн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд 2024 оны эхний 8 сарын байдлаар нийт 2022 багш, ажилтан хамрагдсан.

Хөдөлмөрийн тухай хуулийн 17.5-д заасны дагуу салбарын хэмжээнд анх удаа Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Ажил мэргэжлийн стандарт хүний хөгжлийн хүрээлэн, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл хамтран ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажил мэргэжлийн стандартыг боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 03 дугаар тогтоолоор батлуулсан. Стандартад ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, ажлын байранд тавих шаардлага туссан. Тухайлбал, багшийн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд:

- "Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан орчин нөхцөлд ажиллана.
- Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, тогтоосон норм, нормативыг мөрдөнө.
- Сургалтыг зохион байгуулах явцад суралцагчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад анхаарч, галын болон хөдөлмөрийн аюулгүй

ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, шаардлага, хоолны газрын холбогдох дүрэм журмыг мөрдөнө.

- Гадна талбайн үйлчилгээний явцад байгаль орчныг сүйтгэх (ус, хөрс бохирдуулах, хог хаягдал хаях, амьтан, ургамлын төрөл зүйлийг сүйтгэх г.м.) зэрэг хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө, хор хөнөөл учруулахаас урьдчилан сэргийлсэн байвал зохино.
- Хог хаягдлыг ил задгай хаях, шатаахыг хориглоно.
- Эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамрагдана" гэж заасан.

Дээрх ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажил мэргэжлийн стандартаас гадна сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын багш, багшийн туслах, арга зүйч, эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, захирлын ажил мэргэжлийн стандартын төслийг боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлуулахад бэлэн болсон.

---oOo--